

ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН БИЕ ДААЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хар Бүргэд Уртнасангийн Батцэцэг
ХИС-ийн Баян-Өлгий аймаг дахь салбар
urnasanbattsetseg73@gmail.com

Хураангуй

Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт оюутны бие даалтын ажил гэсэн нэр томъёо бичигдэж, оюутны заавал хийж гүйцэтгэх албадлагын шинжтэй ажлын нэг болсон. Гэвч бие даалтыг хэлбэрийн төдий авч үзэж, гүйцэтгэх болсноос шалтгаалан бие даалтад хандах хандлага билэг тэмдэг, оромдсон шинжтэй болон чанаргүй бичигдэж, сургалтын чанарт, оюутны хөгжилд багагүй сөрөг үр дагавар авч ирж байна. Иймд энэхүү өгүүлэлгүйнхээ агуулгын хүрээнд түүхийн хичээлээр оюутнууд бие даалтыг хэрхэн хийж гүйцэтгэж байгаа болон багшийн зүгээс бие даалтыг удирдан чиглүүлэх ба үнэлж дүгнэх байдалд дүн шинжилгээ хийхийг оролдлоо.

Түлхүүр үг: багшийн үнэлгээ, бие даах ажил, шалгуур үзүүлэлт

Оршил

Уламжлалт сургалтын технологи бол багшаас оюутанд бэлэн их хэмжээний онолын мэдлэгийг дамжуулж, тэдэнд шинжлэх ухааны мэдлэг төлөвшүүлэх явдал байсан. Гэтэл өнөөдөр оюутан бие даан бүтээлч сэтгэлгээтэйгээр сэтгэж өөрийгөө илүү сайн, чадварлаг болгон хөгжүүлэх хэрэгцээ шаардлага гарч ирсэн. Үүнийг хэрэгжүүлэх хөшүүрэг нь их дээд боловсролын сургалтын хөтөлбөрт бие даалт хэмээн нэрлэгдсэн хөгжүүлэх ажил боллоо. Оюутан бие даалт гүйцэтгэхэд багш багагүй үүрэг хариуцлагыг үүрдэг. Үүний тухай Боловсролын тухай хуульд:

1. Багшийн ёс зүй нэр төрийг эрхэмлэн сахих
2. Сургалт хүмүүжлийн ажлыг амьдрал, үйлдвэрлэлтэй уялдуулан шинжлэх ухааны үндэстэй явуулах
3. Онолын мэдлэг, заах арга, ур чадвараа дээшлүүлэх
4. Суралцагчдад бие даан боловсрол, мэргэжил эзэмших чадвар олгох, амьдрах арга ухаанд сургах
5. Хариуцсан ангийн суралцагчдын эрүүл мэндэд анхаарал тавих [5, т-22] хэмээн заасан байдаг.

Үндсэн хэсэг

Боловсролын тогтолцооны гол зорилго нь орчин үеийн хүмүүнлэг, энэрэнгүй, ардчилсан нийгэмд хувьсан хөгжих чадвар бүхий боловсон хүчнийг үйлдвэрлэн гаргах явдал. Дээд боловсролын гол зорилго нь тухайн оршин байгаа нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтолцоонд нийцэн амьдрах, хөтлөн жолоодох, хувьсан хөгжих чадвар бүхий

мэдлэг, чадвар, хандлага, төлөвшил нь бүрдсэн тасралтгүй хөгжих чадвартай монгол улсын иргэнийг бэлтгэх явдал байдаг.

Зах зээлийн нийгэмд суралцагчид урьдынх шиг багшийн хэлсэн үгийг сонсох, бичих, унших зэргээр сурах үйл ажиллагааг хязгаарлаж болохгүй бөгөөд үүний оронд өөрийн амьдрал, ирээдүйн ажил мэргэжилдээ хэрэгтэй тийм мэдлэг чадвар, арга барилыг бие дааж олж эзэмших хэрэгтэй болсон [6, т-50].

Оюутны бие даалт нь сургалтын стандарт, хөтөлбөр нөгөөтэйгүүр оюутны сонирхол чадавхи зэргийг харгалзан хичээлийн болон хичээлийн бус цагаар багшийн шууд бус удирдлага дор явагддаг оюутны бие дааж суралцах бүтээлч үйл ажиллагаа юм [5, т-30].

Оюутны бие даах ажлын гол онцлог нь судалгаа шинжилгээний шинжтэй, бүтээлч үйл ажиллагаа болсоор байгаа явдал юм. Оюутны бие даалт нь:

1. Оюутны заавал хийх ажлын сэдэв,
2. Оюутны сонгож хийх ажлын сэдэв,
3. Оюутан өөрөө сонирхсон сэдвээ дэвшүүлж түүгээрээ судалгаа хийх гэсэн хэд хэдэн янз байна хэмээн судалгааны бүтээлүүдэд тэмдэглэж ирсэн [12, т-26].

Оюутны бие дааж хийх ажлын түвшинг сурган хүмүүжүүлэх ном зохиолд гурав хуваан үздэг. Үүнд:

1. Сэргээн хуулбарлах
2. Өөрчлөн хувиргах
3. Бүтээлч

- Сэргээн хуулбарлах түвшний бие даасан ажлын зорилт бол оюутны мэдлэгийг бататгаж улмаар түүнд чадвар дадал төлөвшүүлэх явдал юм. Энэ тохиолдолд оюутан бэлэн загвар ашиглаж сурах үйлийг хэлнэ. Энэ түвшний ОБДА-ын мөн чанар нь мэдлэгийг таних, ухамсарлах, тогтоох үйл ажиллагаа гүйцэтгэхэд чиглэнэ. Түүнд даалгавар, дасгал гүйцэтгэх, бодлого бодох, коллоквиум өгөх, мэдээлэл хийх, хүснэгт бөглөх гэх мэт ажил багтана.

- Өөрчлөн хувиргах түвшний бие даасан ажлын зорилт бол оюутанд эзэмшсэн мэдлэгээ өөр шинэ нөхцөлд шилжүүлэн хэрэглэх чадвар олгох явдал юм. Үүний тулд оюутнаар уншсан зүйлийн төлөвлөгөө зохиохоос эхлээд тодорхой асуудлаар өөрийн санаа бодлоо найруулан бичих, ажлуудыг хийлгэх зэрэг багтана. Жишээ нь оюутан эссе бичих, бодлого зохиох, реферат бичих гэх зэрэг ажлыг хийнэ.

- Бүтээлч түвшний бие даалтын зорилт бол оюутанд тодорхой үзэгдэл, асуудал, нөхцөл гэх зэрэгт тодорхойлолт өгөх, асуудлыг бие дааж шийдвэрлэх, шинэ мэдлэг бүтээж бий болгох гэх зэрэг арга барилыг эзэмшүүлэх явдал юм. Үүний тулд оюутнаар шийдвэрлэх асуудлыг олуулах, түүнийг хэрхэн шийдэх талаар эрэл хайгуул хийлгэх, төсөл боловсруулах ба судалгаа хийлгэх, судалгааны материалд боловсруулалт хийлгэх, тайлан бичиж хамгаалуулах, ангийн ажил болон дипломын ажил гэх зэргийг хийлгэдэг [7, т-50].

ОБДА-ыг багш сурган хүмүүжүүлэх зарчим, арга барил, үнэлгээний шалгуурыг баримталж үнэлж дүгнэдэг. Хичээл бүрийн онцлог, агуулгын багтаамжаас шалтгаалан оюутны бие даалт бүр өөр өөрийн онцлог шинжтэйгээр хийгддэг. Үүний шалгуур үзүүлэлтийг багш урьдчилан боловсруулж бие даалт гүйцэтгэх оюутнуудад танилцуулсан байх шаардлагатай.

Судалгааны хэсэг

Түүхийн хичээлийн ОБДА нь бие даасан бүтээлч үйл ажиллагаа болж чадаж байгаа эсэх болон багшийн удирдан чиглүүлэх байдал ба үнэлгээний шалгуурыг тодруулан гаргах зорилгоор ХИС-ийн БӨСС-ийн түүх-нийгмийн ухааны багш нар болон 80 /Түүх-Нийгмийн ухааны мэргэжлийн болон мэргэжлийн бус ангийн оюутнуудыг хамруулав/ орчим оюутныг хамруулав.

Судалгаан арга: анкетийн арга болон нээлттэй асуулгын аргуудыг ашиглав.

Судалгааны үр дүн

Судалгаа нь 2 хэсгээс бүрдэнэ. 1 хэсэг нь оюутан бие даалтыг гүйцэтгэж буй байдал, 2 хэсэг нь багшийн удирдан чиглүүлэх байдал ба үнэлгээний асуулгыг багтаасан.

1 хэсэг нь оюутан бие даалтыг гүйцэтгэж буй байдалд дүн шинжилгээ хийхэд оюутнууд бие даалтыг гүйцэтгэхдээ гол төлөв интернет эх сурвалжийг ашигладаг, номын агуулгыг төдийлөн их уншаад байдаггүй, зайлшгүй шаардлагатай тохиолдолд ном уншдаг болох нь харагдаж байна. Үүний зэрэгцээ бие даалтыг оюутан өөрийн хөгжлийн төлөө бус зайлшгүй хийх шаардлагатай ажлын нэг хэмээн үзэж, 3 кредит цагийн багтаамжтай хичээл дээр 3-4 бие даалт хийх үүрэгтэй хэмээн оюутан өөрийгөө хөгжүүлэх бус дүнгийн төлөө, оноогоо алдахгүй авах зорилгоор хийдэг болох нь харагдаж байна.

2 хэсэг нь багшийн удирдан чиглүүлэх байдал ба үнэлгээний асуудал юм. Судалгааны энэ хэсэгт оюутан, багш нараас адилхан асуулгын хүрээнд судалгааг авсан. Багшийн удирдан чиглүүлдэг байдалд оюутнууд харилцан адилгүй хариулт бичжээ. Судалгаанд хамрагдсан оюутнуудын 66% нь багш сайн удирдан чиглүүлж, заавар, зөвлөгөө, аргачлалыг тайлбарлаж өгдөг хэмээн хариулсан бол үлдсэн нь багш нар тодорхой заавар зөвлөгөө өгдөггүй хэмээн хариулжээ. Гэтэл багш нарын

зүгээс зарим оюутнууд бие даалтын сэдвийг авсан цагаасаа асууж тодруулах, заавар, зөвлөгөө авах нь ховорхон, ихэвчлэн хугацаа давчуу болсон үед алдаг оног зүйл асууж, хангалтгүй бие даалт хийх нь элбэг болсон хэмээн харилсан.

Бие даалтын үнэлгээг оюутнуудын 28% нь ойлгодоггүй, 56% нь шударгаар үнэлдэг, 16% нь сайн мэдэхгүй байна гэсэн хариултуудыг өгсөн байна. Үүний зэрэгцээ багшийн өгсөн бие даалт та бүхнийг хөгжүүлэх хөшүүрэг болж чаддаг уу? гэсэн асуултанд харилцан адилгүй хариулсан байна. Багш нарын зүгээс ОБДА-ын бүтэц, агуулга, боловсруулсан байдал, алдаа дутагдал, хамгаалалт зэргийг харгалзан үнэлгээг өгдөг хэмээн хариулжээ.

Дүгнэлт

1. Багш нарын зүгээс оюутныг хөгжүүлэх, чадавхижуулах чиглэлийн бие даалтуудыг өгдөг боловч гүйцэтгэж буй байдал нь амиа аргацаасан, дүнгийн хойноос хөөцөлдсөн, оромдсон шинжтэй болж оюутны бие даасан ажиллагаа байх зарчмаа алдаж байна. Үүний зэрэгцээ багш нарын өгч буй бие даалтууд хэтэрхий олон болж чанар бус тоонд үндэслэж, ОБДА бус хуулбар болон хийгдэх болсон.
2. Багш сурган хүмүүжүүлэгчид ОБДА-д төдийлөн ач холбогдол өгч, цаг хугацаа зарцуулахгүй, заавар, зөвлөгөө өгөхгүй байгаа ба энэ нь их сургуулийн түвшинд багшийн ОБДА-ыг удидсан байдалд үнэлгээ урамшуулал өгдөггүй, сургалтын цагт оруулан тооцохгүй байгаатай холбоотой. Мөн бие даалтын гүйцэтгэл, чанар, хүртээмж, үр дүнд, үнэлгээ зэрэгт хяналт байхгүй байна.
3. Багш сурган хүмүүжүүлэгчид ОБДА-ыг хариуцлагатайгаар цаг, хугацаа зарцуулан удирдах, чиглүүлэх, боловсруулалтанд хяналт тавих шаардлагатай байна.
4. ОБДА-ыг үнэлж буй багшийн үнэлгээ ойлгомжгүй, хүртээмж муутай, тодорхой бус хэмээн дүгнэгдэж, багшийн үнэлгээ оюутнуудын өөрсдийгөө үнэлж буй үнэлгээтэй тохирохгүй байна.

Санал

- ОБДА-ын чанаргүй, бүтээмж муутай байгааг багш бид анхаарч ажиллах, засаж залруулахад багш нарын оролцоо маш өндөр болохыг ухамсарлах.
- ОБДА-ыг удирдаж буй багшид тодорхой урамшуулал олгож, хяналт шалгалтыг давхар гүйцэтгэдэг болох. Бие даалтын ажлын ач холбогдолыг нэмэгдүүлэх.
- Оюутнуудад бие даалт нь заавал хийж гүйцэтгэх албадлагын шинжтэй ажил бус харин та бүхний хөгжлийн хөшүүрэг гэсэн ойлголтыг төлөвшүүлэх, ухамсарлуулах.
- Оюутны бие даалтын тоог цөөрүүлж, чанаржуулахад анхааран, цаашдаа бие даалтыг илүү бүтээл байдалд шилжүүлэх. Тухайлбал:

төсөл хөтөлбөр, илтгэл өгүүлэл, судалгааны ажил болгон үргэлжлүүлэх боломжтой зүйл болгон сургалтын төлөвлөгөөнд тусгах.

- Оюутны бие дааж дээд боловсрол эзэмших чадварыг дээшлүүлэхэд үнэлгээ нь ил тод, нээлттэй, бодитой, ойлгомжтой байх боломжийг олгох.
- Аливаа бүтээлийг шууд хуулбарлах нь оюуны өмчийн хулгай гэдгийг ойлгуулах, таниулах, мөн бие даалтын агуулгад багш ямагт дүн шинжилгээ хийх шаардлагатай.

Зохиогчийн тухай

Уртнасан овогтой Батцэцэг нь 2011 онд Ховд Их Сургуулийг түүх-нийгмийн ухааны багш мэргэжлээр төгсөж, 2012 онд тус сургуулийн Нийгэм, Хүмүүнлэгийн ухааны сургуульд түүхэн газар зүйн чиглэлээр магистрын зэргээ хамгаалсан. 2012 оноос эхлэн ХИС-ийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуульд Түүх-Нийгмийн ухааны багшаар ажиллаж байна.

Ном зүй

1. Алтанцэцэг Т. Заанхүү Ж. (2002) Монголын түүх заах арга. УБ.,
2. Баасандорж Ц. (2020) Сургалтын арга, эрэл, олз. УБ.,2020
3. Золзаяа Х. Амгалан Л. (2010) Оюутны бие даалтын ажилд хийсэн тандах судалгаа / Боловсрол судлал/ сэтгүүл. УБ.№10.
4. Ичинхорлоо Ш. (2013) Сургалт онол, хэрэглээ. УБ.,2013
5. Ичинхорлоо Ш. (2006) Сургалтын арга. УБ.,2006
6. Ичинхорлоо Ш. Дээд сургуулийн сургалт: онол арга зүй. УБ.,2011.т-50